



2019 оны 01 дүгээр сарын 07  
№01/1054/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
хууль**

**Хэлэлцээр соёрхон  
батлах тухай**

**Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол**

**Журам батлах тухай**

**Монгол Улсын  
олон улсын  
гэрээ**

**Эрүүгийн хэргийн талаар эрх  
зүйн туслалцаа харилцан  
үзүүлэх тухай Монгол  
Улсын Засгийн газар, Бүгд  
Найрамдах Хятад Ард Улсын  
Засаг захиргааны онцгой бүс  
Хонконгийн Засгийн газар  
хоорондын хэлэлцээр**

**ГАРЧИГ**  
**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

1.	Хэлэлцээр соёрхон батлах тухай	1
<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b>		
2.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 158 2
3.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 159 2
<b>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</b>		
4.	Журам батлах тухай	Дугаар 271 3
<b>МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ</b>		
5.	Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр	6

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2018 оны 10 дугаар  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн хооронд 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 12 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ гаргасан шүүгч Эрдэнэжаргалын Ариунааг Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, шүүгч Ламжавын Эхлэлтийг Завхан аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 12 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 159

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Монакогийн Хант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мундагбаатарын Батсайханыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Монакогийн Хант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Авирмэдийн Баттөрийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 8 дугаар  
сарын 29-ний өдөр

Дугаар 271

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 38.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшинд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД**

**Ө.ЭНХТҮВШИН**

Засгийн газрын 2018 оны 271 дүгээр  
тогтоолын хавсралт

### ГАМШГААС ХАМГААЛАХ ДОТООДЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖИЙГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд зориулж Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд, хувь хүн (Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суудаг гадаадын иргэн болон харьяалалгүй хүн)-ээс үзүүлэх хандив, тусламж (цаашид “дотоодын хүмүүнлэгийн тусламж” гэх)-аар ирүүлсэн бараа, материал, мөнгөн хөрөнгийг хүлээн авч байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах, зарцуулах, тайлагнах харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гамшгийн улмаас учирсан хохирол, хэрэгцээний үнэлгээг үндэслэн дотоодын хүмүүнлэгийн тусламж хүсэх, уриалга гаргах шийдвэрийг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутагт тухайн шатны Засаг дарга гаргана.



Хоёр. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг  
хүлээн авах, хадгалах

2.1. Мөнгөн хөрөнгөөр үзүүлсэн дотоодын хүмүүнлэгийн тусламжийг Төрийн сангийн нэмэлт дансанд хүлээн авч бүртгэнэ.

2.2. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ажлын хэсэг томилж дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалыг хүлээн авах, бүртгэх, байршуулан хадгалах ажлыг зохион байгуулна.

2.3. Ажлын хэсэг дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материал Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандарт, хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэхэд хяналт тавих бөгөөд шаардлагатай тохиолдолд чанарын байдалд холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулж болно.

2.4. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалыг эрүүл ахуйн болон галын аюулгүй байдал, стандартын шаардлага хангасан агуулахад технологийн дагуу түр хадгална.

2.5. Шаардлагатай тохиолдолд дотоодын хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч этгээдийн агуулахад түр хугацаагаар хадгалуулж болох бөгөөд уг агуулах нь энэхүү журмын 2.4-т заасан шаардлагыг хангасан байна.

2.6. Хадгалалтын тусгай горим, технологи шаардсан тусламжийн бараа, материалыг аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан хадгалуулж болох бөгөөд гэрээнд барааны чанар, стандарт, хадгалах хугацаа, төлбөр, барааны нэр төрөл, тоо хэмжээ, үнэ, талуудын хүлээх хариуцлага, мэдээ тайлангийн талаар тодорхой тусгасан байна.

Гурав. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг  
хуваарилах, зарцуулах

3.1. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг аж ахуйн нэгж, байгууллагаас тусгайлан нэр зааж ирүүлэхээс бусад тохиолдолд хэрэгцээ шаардлагыг үндэслэн хуваарилан олгох асуудлыг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутаг тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ.

3.2. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу тухайн шатны Засаг дарга дотоодын хүмүүнлэгийн тусламжийг шаардлагатай газарт хуваарилах, олгох ажлыг шуурхай зохион байгуулж, үр дүнг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнана.



#### Дөрөв. Хүмүүнлэгийн тусламжийн барааг тээвэрлэх

4.1. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалыг шаардлагатай газарт хүргэх, тээвэрлэх асуудлыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

4.2. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалын чанар, аюулгүй байдал, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг тухайн орон нутгийн Засаг дарга хариуцна.

4.3. Дотоодын хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч тал хүсэлт гаргасан тохиолдолд үзүүлсэн тусламжаа хуваарилах, тээвэрлэн хүргэх ажлыг зохион байгуулж болох бөгөөд холбогдон гарах зардлаа өөрөө хариуцаж, тухайн шатны Засаг дарга болон онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавьж ажиллана.

Тав. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалыг хадгалах, тээвэрлэх болон бусад үйл ажиллагааны зардал, тайлан бүртгэл

5.1. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авч байршуулах, хадгалах, хуваарилах, тээвэрлэн хүргэх болон бусад үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутгийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ.

5.2. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дотоодын хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааг зохион байгуулсан тухай тайлан мэдээг нэгтгэн, дотоодын хүмүүнлэгийн тусламж үзүүлсэн аж ахуйн нэгж, холбогдох байгууллагад албан бичгээр тайлагнаж, олон нийтэд цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлнэ.

5.3. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутагт онцгой байдлын байгууллага хэрэгжүүлнэ.

#### Зургаа. Бусад

6.1. Орон нутагт хуваарилсан дотоодын хүмүүнлэгийн тусламжийн зарцуулалтад Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

6.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.



## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

### ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ ОНЦГОЙ БҮС ХОНКОНГИЙН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Төв Засгийн газраас энэхүү хэлэлцээрийг байгуулах бүрэн эрхийг авсан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн (“ЗЗОБ Хонконг”) Засгийн газар (цаашид “талууд” гэх),

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлж, хамтран ажиллах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн байцаах, яллах болон гэмт хэргийн улмаас олсон орлогыг хураан авахад хоёр талын хууль сахиулах үр нөлөөг сайжруулахыг эрмэлзэн,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:

#### **1 дүгээр зүйл**

#### **Туслалцааны хамрах хүрээ**

1. Талууд энэхүү хэлэлцээрийн заалтын дагуу эрүүгийн хэргийн талаар өргөн хүрээнд туслалцаа үзүүлэх арга хэмжээ авна.

2. Энэхүү хэлэлцээрийн зорилгоор эрүүгийн хэргийн талаар гэдэгт туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлтийг гаргах үед хүсэлт гаргагч талын эрх бүхий байгууллагын харьяаллын хүрээнд байгаа аливаа хэрэгт мөрдөн байцаах, яллах, эсхүл байцаан шийтгэх ажиллагаа явуулахыг ойлгоно.

3. Туслалцаанд дараахь зүйл хамаарна. Үүнд:

- (a) холбогдох этгээдээс мэдүүлэг, эсхүл нотлох баримт авах;
- (b) мэдээлэл, баримт бичиг, тэмдэглэл болон нотлох эд зүйлсээр хангах;
- (c) аливаа этгээдийг, эсхүл зүйлийг таних, эсхүл хайж олох;
- (d) баримт бичиг гардуулах;



(e) нэгжлэг хийх болон хураан авах хүсэлтийг гүйцэтгэх;

(f) хоригдож байгаа этгээд болон өөр бусад этгээдээс мэдүүлэг авах, эсхүл мөрдөн шалгах ажиллагаанд туслалцаа үзүүлэх боломжийг хангах;

(g) гэмт үйлдэлд ашигласан хэрэгсэл болон олсон орлогыг эрж олох, зогсоох, хураах;

(h) эд хөрөнгийг илгээх, эд хөрөнгийг буцаан өгөх болон эд мөрийн баримтыг түр өгөх;

(i) хүсэлт хүлээн авагч талын хуульд харшлаагүй бөгөөд энэхүү хэлэлцээрийн зорилгод нийцсэн бусад хэлбэрийн туслалцаа.

4. Энэхүү хэлэлцээрийн дагуу туслалцаа нь тухайн гэмт хэрэгт мөрдөн байцаах ажиллагаа явуулах тохиолдолд мөрдөн байцаалтын үндсэн зорилго нь татвар хураах, эсхүл ногдуулахтай холбоогүй байх бөгөөд туслалцааг татвар, гаалийн хураамж, эсхүл бусад орлогын асуудлаарх хууль зөрчсөн эрүүгийн гэмт хэрэгт холбогдуулан үзүүлж болно.

5. Энэхүү хэлэлцээр нь талуудын хооронд гагцхүү харилцан туслалцаа үзүүлэхэд чиглэгдсэн байна. Энэхүү хэлэлцээрийн заалт нь аливаа нотлох баримтыг авах, нуун дарагдуулах, эсхүл хасах болон хүсэлтийг хэрэгжүүлэхэд саад учруулж байгаа аливаа хувь этгээдийн эрхийг эдлүүлэхгүй.

6. Энэхүү хэлэлцээр нь дараахь зүйлд хамаарахгүй. Үүнд:

(a) гэмт хэрэгтэн хэргээ хүлээх;

(b) энэхүү хэлэлцээр болон хүсэлт хүлээн авагч талын хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хүсэлт гаргагч талын оногдуулсан шүүхийн шийдвэрийг хүсэлт хүлээн авагч талд гүйцэтгэх;

(c) ял эдлүүлэхээр ялтныг шилжүүлэх;

(d) эрүүгийн хэргийн байцаан шийтгэх ажиллагааг шилжүүлэх.





## **2 дугаар зүйл** **Бусад тохиролцоо**

Энэхүү хэлэлцээр нь бусад хэлэлцээр, тохиролцооны дагуу харилцан бие биендээ туслалцаа үзүүлэх ажиллагааг үргэлжлүүлэх, эсхүл үзүүлэхээс талуудыг сэрэмжлүүлэх, эсхүл өөр хэлэлцээр, тохиролцооны дагуу талуудын хооронд үүссэн үүргийг хөндөхгүй.

## **3 дугаар зүйл** **Эрх бүхий төв байгууллага**

1. Энэхүү хэлэлцээрийн зорилгоор тал тус бүр хүсэлт гаргах, эсхүл хүлээн авах эрх бүхий төв байгууллагыг томилно. Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн эрх бүхий төв байгууллага нь Хууль зүйн нарийн бичгийн дарга, эсхүл түүнээс бүрэн эрх олгосон ажилтан. Монгол Улсын эрх бүхий төв байгууллага нь Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдаас бүрэн эрх олгосон ажилтан. Аль нэг тал эрх бүхий төв байгууллагаа өөрчилж болох бөгөөд энэхүү өөрчлөлтийн талаар нөгөө талдаа мэдэгдэнэ.

2. Эрх бүхий төв байгууллагууд энэхүү хэлэлцээрийн зорилгоор хоорондоо шууд харилцана.

## **4 дүгээр зүйл** **Туслалцаа үзүүлэхээс татгалзах, эсхүл хойшлуулах**

1. Хүсэлт хүлээн авагч талын саналаар дараахь тохиолдолд туслалцаа үзүүлэхээс татгалзана. Үүнд:

(a) хүсэлтийг гүйцэтгэх нь түүний суурь ашиг сонирхлыг хөндөхөөр байгаа бол;

(b) хүсэлтийг гүйцэтгэх нь Монгол Улс, эсхүл Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн хувьд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, эсхүл нийгмийн хэв журмыг хөндөхөөр бол;

(c) туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлтийг аливаа этгээдийн гарал үүсэл, хүйс, шашин шүтлэг, харьяалал, улс төрийн үзэл



бодлын үндсэн дээр яллаж, эсхүл шийтгэхээр гаргасан болон эдгээр шалтгаанаар тухайн этгээдийн байр сууринд сөргөөр нөлөөлж болохыг илтгэх хангалттай үндэслэл байгаа бол;

(d) хэрэв хүсэлт хүлээн авагч талын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэгт сэжиглэж байгаа үйлдэл, эс үйлдэл нь хүсэлт хүлээн авагч талын хуулиар гэмт хэрэгт тооцогдохгүй бол;

(e) улс төрийн шинжтэй гэмт хэрэгтэй холбоотой хүсэлт;

(f) аль нэг талын харьяалах шүүх, эсхүл эрх бүхий өөр байгууллагаас гэм буруутайд тооцсон, цагаатгасан, өршөөл үзүүлсэн болон уг гэмт хэрэгтээ хуульд заасан ялаар шийтгэгдсэн этгээдийг уг гэмт хэрэгт, эсхүл тухайн үйлдэл, эс үйлдлийг өөр гэмт хэрэгтэй холбогдуулан яллахтай холбогдсон хүсэлт.

2. Туслалцаа үзүүлэх хүсэлт нь зөвхөн цэргийн хуулиар шийдвэрлэх гэмт хэрэгт холбогдох бол хүсэлт хүлээн авагч тал туслалцаа үзүүлэхээс татгалзаж болох бөгөөд өөрийн улсын хуульд заасан тохиолдолд татгалзана.

3. Хүсэлт гаргагч тал нь хүсэлт хүлээн авагч талд цаазаар авах ялыг оногдуулахгүй, оногдуулсан тохиолдолд гүйцэтгэхгүй байх хангалттай нотолгоог гаргаж өгөөгүй тохиолдолд хүсэлт хүлээн авагч талд цаазаар авах ял оногдуулдаггүй бөгөөд гүйцэтгэдэггүй боловч хүсэлт гаргагч талд цаазаар авах ял оногдуулахаар гэмт хэрэгтэй холбогдсон хүсэлтэд хүсэлт хүлээн авагч тал туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

4. Хүсэлт хүлээн авагч тал хүсэлтийг биелүүлэх нь тухайн талд явуулж байгаа мөрдөн байцаах, эсхүл яллах ажиллагаанд хөндлөнгөөс оролцохоор байвал туслалцаа үзүүлэхээ хойшлуулж болно.

5. Хүсэлт хүлээн авагч тал нь энэхүү зүйлд заасан туслалцааг хойшлуулах, эсхүл татгалзахаас өмнө өөрийн эрх бүхий төв байгууллагаараа дамжуулан дараах арга хэмжээг авна. Үүнд:

(a) Хүсэлт гаргагч талд татгалзах, эсхүл хойшлуулах болсон шалтгаанаа нэн даруй мэдэгдэх;



(b) Хүсэлт хүлээн авагч талын шаардлагатай гэж үзсэн хугацаа болон нөхцөлийн хүрээнд туслалцааг үзүүлж болох эсэхийг тодорхойлохоор хүсэлт гаргагч талтай зөвлөлдөх.

6. Хэрэв хүсэлт гаргагч тал туслалцааг энэ зүйлийн 5 дахь хэсгийн б-д заасан хугацаа болон нөхцөлийн хүрээнд үзүүлэхийг хүлээн зөвшөөрвөл түүнийг тухайн хугацаа болон нөхцөлтэй нийцүүлнэ.

7. Хүсэлт хүлээн авагч тал нь хүсэлт гаргагч талд хүсэлтийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн дагаж мөрдөх боломжгүй байгаа шийдвэрийг болон уг шийдвэрийн шалтгааныг нэн даруй мэдэгдэнэ.

### **5 дугаар зүйл** **Хүсэлтийн агуулга**

1. Хүсэлтэд дор дурдсан зүйлийг тусгана. Үүнд:

(a) эрүүгийн хэргийн асуудлаар хүсэлт гаргаж байгаа эрх бүхий байгууллагын нэр, тэр дундаа хариуцсан хүний нэр, түүнтэй холбоо барих дэлгэрэнгүй мэдээлэл;

(b) хүсэлтийн зорилго болон хүсэж байгаа туслалцааны тайлбар;

(c) тухайн асуудлын тайлбар, эрүүгийн хэргийн онцлог, тэр дундаа эрүүгийн хэрэгтэй холбоотой гэмт хэрэгт оногдуулах хамгийн хүнд шийтгэл, холбогдох үйл баримт болон хуулийн хураангуй;

(d) хүсэлтийг хэрэгжүүлэхэд анхаарах аливаа цаг хугацааны хязгаар;

(e) хүсэлтийг хэрэгжүүлэхдээ дагаж баримтлах аливаа нэг тусгай журам, эсхүл шаардлагын талаарх танилцуулга;

(f) нууцлалын шаардлага болон түүний шалтгаан;

(g) хүсэлтийг хэвийн гүйцэтгэхэд шаардлагатай бусад мэдээлэл.

2. Туслалцаа хүссэн хүсэлтэд шаардлага болон бололцооны хүрээнд дараах мэдээллийг тусгана. Үүнд:

(a) нотлох баримт авах этгээдийн хувийн шинж, харьяалал болон байршлын талаарх мэдээлэл;

(b) баримт бичиг гардуулах этгээдийн хувийн шинж болон байршил, түүний байцаан шийтгэх ажиллагаатай харилцан хамаарал болон гардуулж өгөх арга замын талаарх мэдээлэл;

(c) этгээдийн байршиж буй газар болон хувийн шинжийн талаарх мэдээлэл;

(d) нэгжлэг хийх газар болон хураан авах эд зүйлсийн тайлбар;

(e) хүсэлт гаргагч талд ирүүлэхийг хүссэн этгээдийн авах тэтгэмж болон зардлын талаарх мэдээлэл.

3. Хэрэв хүсэлт хүлээн авагч тал хүсэлтэд дурдсан мэдээлэл хүсэлтийг хэрэгжүүлэхэд хангалттай бус гэж үзвэл нэмэлт мэдээлэл хүсэж болно.

4. Хүсэлтийг бичгээр гаргана.

5. Энэхүү хэлэлцээрийн дагуу хүсэлт, түүний дагалдах баримт бичиг болон бусад захидлыг англи хэлээр үйлдэх бөгөөд хэрэв хүсэлт гаргавал хүсэлт хүлээн авагч талын албан ёсны хэл дээрх орчуулгыг хавсаргана.

### **6 дугаар зүйл** **Хүсэлтийг гүйцэтгэх**

1. Туслалцаа хүссэн хүсэлтийг хүсэлт хүлээн авагч талын хуульд нийцүүлэн, тухайн хуулиар хориглоогүй заалтын хүрээнд хүсэлт гаргагч талын тодорхойлсон хэлбэрээр бололцооны хэмжээнд даруй гүйцэтгэнэ.

2. Хүсэлт хүлээн авагч тал нь хүсэлтийн хариуг хойшлуулахаар болж байгаа аливаа нөхцөл, шалтгааны талаар хүсэлт гаргагч талд даруй мэдэгдэнэ.



**7 дугаар зүйл**  
**Хүсэлт хүлээн авагч талд материалыг буцаах**

Хүсэлт хүлээн авагч тал шаардвал энэхүү хэлэлцээрийн дагуу олгосон материалыг хүсэлттэй холбоотой эрүүгийн хэрэгт цаашид шаардлагагүй болсон гэж үзвэл хүсэлт гаргагч тал нэн даруй буцааж өгнө.

**8 дугаар зүйл**  
**Нууцлал**

Хүсэлт гаргавал хүсэлт хүлээн авагч тал хүсэлт, түүний агуулга, дагалдах баримт бичиг болон хүсэлтийн дагуу авах аливаа арга хэмжээний талаар нууцлалыг хадгалахдаа дээд зэргийн хүчин чармайлт гаргана. Хэрэв тухайн хүсэлтийг хүсэлт гаргасан нууцлалыг задруулахгүйгээр хэрэгжүүлэх боломжгүй бол хүсэлт хүлээн авагч тал хүсэлтийг хэрэгжүүлэх эсэхийг тодорхойлох зорилгоор хүсэлт гаргагч талд мэдэгдэнэ.

**9 дүгээр зүйл**  
**Ашиглалтын хязгаарлал**

1. Хүсэлт гаргагч тал хүсэлт хүлээн авагч талаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр хүсэлтэд зааснаас бусад зорилгоор энэхүү хэлэлцээрийн дагуу олж авсан мэдээлэл, эсхүл нотлох баримтыг задруулж, эсхүл ашиглахгүй.

2. Хүсэлт хүлээн авагч тал бичгээр зөвшөөрөл олгосон тохиолдолд болон хүсэлтэд дурдсан эрүүгийн хэрэгт шаардлагатай нотлох баримт болон мэдээллээс бусад тохиолдолд хүсэлт гаргагч тал хүсэлт хүлээн авагч талын өгсөн нотлох баримт болон мэдээллийг хүсэлт гаргасан тохиолдолд нууцад хадгална.

3. 1, эсхүл 2 дахь хэсэгт заасны дагуу хүсэлт гаргагч талд олон нийтэд ил болсон мэдээлэл болон нотлох баримтыг цаашид аливаа зорилгоор ашиглаж болно.

**10 дугаар зүйл**  
**Нотлох баримт, эд зүйл, эсхүл баримт**  
**бичиг олж авах**

1. Хүсэлт хүлээн авагч тал өөрийн хууль болон хүсэлтийг үндэслэн аливаа этгээдээс мэдүүлэг авах, эсхүл мэдэгдлийг өөр аргаар олж авах



болон тэдгээрээс хүсэлт гаргагч талд шилжүүлэх нотлох баримтын эд зүйлийг гаргаж тавихыг шаардана.

2. Энэ зүйлийн дагуу гаргах хүсэлтийн зорилгын хүрээнд хүсэлт гаргагч тал гэрчид тавих асуулт, эсхүл шалгаж байгаа асуудлын сэдвийн талаар тусгана.

3. Хүсэлт хүлээн авагч тал өөрийн хуулиар зөвшөөрсөн заалтын хүрээнд хүсэлтийг гүйцэтгэх явцад хүсэлтэд дурдсан тухайн этгээдийг оролцуулахыг зөвшөөрөх бөгөөд уг этгээдэд мэдүүлэг, эсхүл нотлох баримт авах этгээдээс байцаалт авахыг зөвшөөрч болно. Шууд байцаалт авахыг зөвшөөрөхгүй тохиолдолд уг этгээдэд мэдүүлэг, эсхүл нотлох баримт авах этгээдээс асуух асуулт өгөхийг зөвшөөрнө.

4. Энэ зүйлийн дагуу хүсэлт хүлээн авагч талын нотлох баримт өгөхөөр шаардагдсан этгээд дараах тохиолдолд нотлох баримт гаргаж өгөхөөс татгалзаж болно. Үүнд:

(a) Хүсэлт хүлээн авагч талын хуулиар хүсэлт хүлээн авагч талаас үүсгэсэн эрүүгийн хэрэгтэй ижил нөхцөл байдалд нотлох баримт өгөхөөс татгалзаж болохыг тухайн этгээдэд зөвшөөрсөн бол;

(b) Хүсэлт гаргагч талын хуулиар хүсэлт гаргагч талын тухайн эрүүгийн хэрэгт нотлох баримт өгөхөөс татгалзахыг түүнд зөвшөөрсөн бол.

5. Энэ зүйлийн дагуу хүсэлт хүлээн авагч талын нотлох баримт өгөх шаардлагатай этгээдээс хүсэлт гаргагч талын хуулийн дагуу нотлох баримт өгөхөөс татгалзах эрхтэй гэсэн шаардлага гаргасан бол нотлох баримтыг ямартай ч авч хүсэлт гаргагч талын эрх бүхий байгууллагаар нөхөн шийдвэр гаргуулахаар тухайн талын эрх бүхий төв байгууллагад уг шаардлагын талаар мэдэгдэнэ.

### **11 дүгээр зүйл** **Цахим хурал**

Талууд өөрсдийн бололцоо, эсхүл хуультай нийцүүлэн тухайн хэрэг тус бүрээс шалтгаалан мэдүүлгийг цахим хурлын тусламжтайгаар авахаар тохиролцож болно. Энэ тохиолдолд хоёр тал цахим хурал хийх тусгай дэг журмыг тохиролцоно.



### **12 дугаар зүйл**

#### **Нотлох баримт өгөх, эсхүл мөрдөн байцаах ажиллагаанд туслалцаа үзүүлэх зорилгоор хоригдож байгаа этгээдийг шилжүүлэх**

1. Энэхүү хэлэлцээрт заасны дагуу, хэрэв хүсэлт хүлээн авагч тал зөвшөөрвөл, мөрдөн байцаах ажиллагаанд туслалцаа үзүүлэх, эсхүл шүүн таслах ажиллагаанд гэрч, шинжээчээр оролцуулах зорилгоор хүсэлт гаргагч талд байлцуулах шаардлагатай хүсэлт хүлээн авагч талд хоригдож байгаа этгээдийг өөрийнх нь зөвшөөрөл болон хүсэлт гаргагч талаас уг этгээдийг үргэлжлүүлэн хорьж байгаад хүсэлт хүлээн авагч талд буцаан хүргүүлэх баталгааг гаргаж өгсөн тохиолдолд хүсэлт хүлээн авагч талаас хүсэлт гаргагч талд шилжүүлнэ.

2. Энэ зүйлд заасны дагуу шилжүүлсэн этгээдийн хорих ялын хугацаа түүнийг хүсэлт гаргагч талд байхад дуусгавар болсон тохиолдолд хүсэлт хүлээн авагч тал түүнийг хорих ялаас чөлөөлөхийг хүсэлт гаргагч талд зөвлөнө.

### **13 дугаар зүйл**

#### **Туслалцаа үзүүлэх зорилгоор бусад этгээдийг ирүүлэх**

1. Хүсэлт гаргагч тал энэхүү хэлэлцээрийн дагуу эрүүгийн хэргийн талаар туслалцаа үзүүлэх зорилгоор аливаа этгээдийг урьж ирүүлэх хүсэлтийг хүсэлт хүлээн авагч талд гаргаж болно. Хүсэлт гаргагч тал зардал болон мөнгөн тэтгэмжийг ямар хэмжээнд хариуцах талаар тусгана.

2. Уг хүсэлтийг хүлээн авсны дараа хүсэлт хүлээн авагч тал тухайн этгээдийг хүсэлт гаргагч талд зорчихыг урина. Хүсэлт хүлээн авагч тал уг этгээдээс авсан хариуг хүсэлт гаргагч талд нэн даруй мэдэгдэнэ.

### **14 дүгээр зүйл**

#### **Аюулгүйн ажиллагаа**

1. 12 болон 13 дугаар зүйлд заасны дагуу гаргасан хүсэлтээр хүсэлт гаргагч талд байгаа этгээд нь хүсэлтэд хамаарах байцаан шийтгэх ажиллагаа, эсхүл мөрдөн байцаах ажиллагаанаас өөр бусад мөрдөн байцаах ажиллагаанд туслалцаа үзүүлэх, эсхүл байцаан шийтгэх ажиллагаанд нотлох баримт өгөх үүрэг хүлээхгүй.



2. 12 болон 13 дугаар зүйлд заасны дагуу гаргасан хүсэлтийг зөвшөөрөөгүй этгээд хүсэлт, эсхүл зарлан дуудахад эсрэг мэдэгдэл хийснийг үл харгалзан энэ шалтгаанаар аливаа шийтгэл, албадлагын арга хэмжээ авах хариуцлага хүлээхгүй.

3. 12 болон 13 дугаар зүйлд заасны дагуу туслалцаа үзүүлэхийг зөвшөөрсөн этгээдийг:

(а) 12 дугаар зүйлд зааснаас гадна хүсэлт хүлээн авагч талаас гарч явснаар түүнийг хүсэлт гаргагч талд аливаа эрүүгийн гэмт хэрэгт яллах, хорих, эсхүл түүний хувийн эрх чөлөөг хязгаарлахгүй;

(b) тухайн этгээдийн хүсэлт хүлээн авагч улсаас гарч явахаасаа өмнө үйлдсэн гэж сэжиглэгдэж буй аливаа үйлдэл, эс үйлдэлд холбогдох иргэний нэхэмжлэлд уг этгээдийг холбогдуулахгүй бөгөөд хэрэв тухайн этгээд хүсэлт гаргагч талд байхгүй байсан бол иргэний нэхэмжлэлд холбогдуулж, субъект нь болохгүй.

4. Хэрэв хоригдож байгаад 12 дугаар зүйлд заасны дагуу шилжүүлэгдсэн бус буюу гарч явах нь чөлөөтэй байсан этгээд түүнд цаашид байх шаардлагагүй болсныг мэдэгдсэнээс хойш 15 хоногийн хугацаанд хүсэлт гаргагч талаас гарч яваагүй, эсхүл хүсэлт гаргагч талаас гарч явсан боловч буцаад ирсэн бол энэ зүйлийн 1 болон 3 дахь хэсэг хамаарахгүй.

5. 12 эсхүл 13 дугаар зүйлд заасны дагуу нотлох баримт өгөхийг зөвшөөрсөн этгээд худал мэдүүлэг өгсөн, эсхүл шүүхийг үл хүндэтгэсэнээс бусад тохиолдолд түүнийг өгсөн мэдүүлэг дээр нь үндэслэж яллахгүй.

### **15 дугаар зүйл**

#### **Олон нийтэд нээлттэй болон албан ёсны баримт бичиг өгөх**

1. Хүсэлт хүлээн авагч тал нь улсын бүртгэлийн хэсэг болсон олон нийт хандахад нээлттэй, эсхүл олон нийт худалдаж авах боломжтой баримт бичиг болон тэмдэглэлийн хуулбарыг өгнө.

2. Хүсэлт хүлээн авагч тал Засгийн газрын байгууллага, агентлагийн эзэмшилд байгаа нийтэд ил болоогүй аливаа баримт бичиг, тэмдэглэл,





мэдээллийн хуулбарыг өөрийн хууль хяналтын болон шүүх эрх бүхий байгууллагад нээлттэй байж болох баримт бичиг, тэмдэглэл, мэдээлэлтэй адил нөхцөл, адил хүрээнд хүргүүлж болно.

### **16 дугаар зүйл**

#### **Баримт бичиг гардуулах**

1. Хүсэлт хүлээн авагч тал нь гардуулах зорилгоор хүсэлт гаргагч талаас түүнд шилжүүлсэн баримт бичгийг гардуулна.

2. Хүсэлт гаргагч талд хүрэлцэн ирэхийг шаардсан баримт бичгийг гардуулах хүсэлтийг хүрэлцэн ирсэн байх өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө хүсэлт хүлээн авагч талд хүргүүлнэ. Яаралтай тохиолдолд хүсэлт хүлээн авагч тал энэхүү шаардлагыг дагахгүй байж болно.

3. Хүсэлт гаргагч талд хүрэлцэн ирэх тухай баримт бичгийг гардуулах хүсэлтэд хүсэлт гаргагч талын эрх бүхий байгууллага тухайн этгээдийн эсрэг үүсгэсэн эрүүгийн хэрэгт олгосон зөвшөөрөл болон шүүхийн бусад шийдвэрийн үндэслэл бүхий мэдэгдлийг оруулна.

4. Хүсэлт хүлээн авагч тал нь хүсэлт гаргагч талын шаардсан хэлбэрээр гардуулсныг нотлох баримтыг өөрийн хуулийн дагуу хүсэлт гаргагч талд хүргүүлнэ. Гардуулсныг нотлох баримт гэдэгт гардуулсан хэлбэр, огноо, газрын тухай тайлбар болон баримт бичиг гардаж авсан этгээдийн гарын үсэг зурсан баримтыг оруулж болно.

5. Баримт бичиг гардан авсан этгээд аливаа ажиллагааг биелүүлээгүй бол энэ шалтгаанаар хүсэлт гаргагч тал, эсхүл хүсэлт хүлээн авагч талын хуулийн дагуу аливаа ял, эсхүл албадлагын арга хэмжээ хүлээхгүй.

### **17 дугаар зүйл**

#### **Нэгжлэг хийх болон хураан авах**

1. Хүсэлт хүлээн авагч тал хүсэлт гаргагч талд шалгаж байгаа эрүүгийн хэрэгт холбогдуулан нэгжлэг хийх, хураан авах болон аливаа материалыг илгээхийг хүссэн хүсэлтийг өөрийн хуулиар зөвшөөрсөн хүрээнд хэрэгжүүлэх бөгөөд тийм арга хэмжээ нь хүсэлт гаргагч талын хуулиар зөвшөөрснийг нотолсон тухай мэдээллийг уг хүсэлтэд тусгана.



2. Хүсэлт хүлээн авагч тал нь хүсэлт гаргагч талаас шаардвал нэгжлэгийн үр дүн, хураан авсан газар, түүний нөхцөл байдал, хураасан материалын цаашдын хадгалалтын талаарх мэдээллийг өгнө.

3. Хүсэлт гаргагч тал түүнд ирүүлсэн аливаа эд хөрөнгийг хураан авахтай холбогдуулан хүсэлт хүлээн авагч талаас тавьсан аливаа нөхцөл шаардлагыг дагаж мөрдөнө.

### **18 дугаар зүйл**

#### **Гэмт хэргийн замаар олсон орлого**

1. Хүсэлт хүлээн авагч тал хүсэлтийг хүлээн авснаар хүсэлт гаргагч талын хуулийг зөрчсөн гэмт хэргийн замаар олсон орлого хүсэлт хүлээн авагч талын нутаг дэвсгэрт байгаа эсэхийг олж тогтоох талаар хүчин чармайлт гаргах бөгөөд түүний үр дүнг хүсэлт гаргагч талд мэдэгдэнэ. Хүсэлт гаргагч тал хүсэлт гаргахдаа хүсэлт хүлээн авагч талын нутаг дэвсгэрт тухайн орлого байж болох үндэслэлээ мэдэгдэнэ.

2. Хэрэв 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт сэжиглэж байсан орлого олдрол хүсэлт хүлээн авагч тал хүсэлт гаргагч талын шүүхээс эцсийн шийдвэр гаргах явцад гэмт хэрэгт сэжиглэсэн орлогыг арилжаа хийх, шилжүүлэх, борлуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг өөрийн хуулиар зөвшөөрсөн хүрээнд авна.

3. Тухайн орлогыг аюулгүй хураахад туслалцаа үзүүлэхийг хүсвэл хүсэлт хүлээн авагч тал өөрийн хуулийн хүрээнд туслалцаа үзүүлэх арга хэмжээ авна. Тухайлбал, хүсэлт гаргагч талын шүүхээс гаргасан тогтоолыг хэрэгжүүлэх болон хүсэлтэд хамаарах орлоготой холбогдсон байцаан шийтгэх ажиллагааг эхлүүлэх болон туслалцаа үзүүлэх зэрэг болно.

4. Энэ зүйлийг хэрэглэхдээ хүсэлт хүлээн авагч талын хуулийн дагуу гуравдагч талын хууль ёсны эрхийг хүндэтгэнэ.

5. Талууд өөрөөр тохиролцоогүй бол энэхүү хэлэлцээрийн дагуу хураагдсан орлого хүсэлт хүлээн авагч талд үлдэнэ.

### **19 дүгээр зүйл**

#### **Гэрчлэх болон баталгаажуулах**

1. Аль нэг тал хүсэлт гаргаагүй бол туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлт болон дагалдах баримт бичиг түүнчлэн тухайн хүсэлтийн хариуд



ирүүлсэн баримт бичиг, бусад материалыг гэрчлэх, баталгаажуулах шаардлагагүй.

2. Хүсэлт хүлээн авагч талын хуулиар хориглоогүй боловч хүсэлт гаргагч талын хуулийн дагуу баримт бичиг, тэмдэглэл болон бусад материалыг хууль ёсны болгохын тулд тэдгээрийг гэрчилсэн хэлбэрээр, эсхүл гэрчилсэн баримтыг хавсаргаж дамжуулах бөгөөд уг асуудлаар хүсэлт хүлээн авагч талд хүсэлт гаргаж болно.

3. Зөвхөн тухайн талын хуулиар тусгайлан шаардсан бол материалыг консулын, эсхүл дипломат ажилтан гэрчлэх буюу баталгаажуулна.

### **20 дугаар зүйл** **Төлөөлөл болон зардал**

1. Хүсэлт хүлээн авагч тал нь хүсэлтээс үүдэн гарах байцаан шийтгэх ажиллагаанд хүсэлт гаргагч талыг төлөөлөн шаардлагатай бүх арга хэмжээг авах бөгөөд бусад бүх асуудлаар хүсэлт гаргагч талын ашиг сонирхлыг төлөөлнө.

2. Хүсэлт хүлээн авагч тал нь өөрийн нутаг дэвсгэрт хүсэлтийг гүйцэтгэхэд гарах, хүсэлт гаргагч талын хариуцах дор дурдсан зардлаас бусад нийтлэг зардлыг хариуцна. Үүнд:

(а) хүсэлт гаргагч талын хүсэлтээр хүсэлт хүлээн авагч талын нутгаас ирж очихтой холбогдсон замын зардал болон 12 эсхүл 13 дугаар зүйлд заасан хүсэлтийн дагуу хүсэлт гаргагч талд байх үед тухайн этгээдэд олгох аливаа хэрэглээний зардал;

(b) хүсэлт гаргагч талын хүсэлтээр хөлсөлсөн зөвлөх болон шинжээчийн төлбөр болон зардал.

3. Хүсэлтийг гүйцэтгэх явцад тухайн хүсэлтийг биелүүлэхэд хэт их, бүр үлэмж их хэмжээний зардал шаардлагатай болох нь тодорхой бол хүсэлтийг гүйцэтгэхэд шаардагдах хугацаа болон нөхцөлийг тодорхойлох зорилгоор талууд зөвлөлдөнө.



### **21 дүгээр зүйл Зөвлөгөөн**

Талууд энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, хэрэглэх, эсхүл хэрэгжүүлэхтэй холбогдон аль нэг талын хүсэлтээр нэн даруй зөвлөлдөнө.

### **22 дугаар зүйл Маргаан шийдвэрлэх**

Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, хэрэглэх, эсхүл хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн аливаа маргааныг эрх бүхий төв байгууллагууд тохиролцоонд хүрч шийдвэрлэх боломжгүй бол асуудлыг дипломат шугамаар шийдвэрлэнэ.

### **23 дугаар зүйл Хүчин төгөлдөр болох, нэмэлт, өөрчлөлт оруулах болон цуцлах**

1. Тал тус бүр энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болоход шаардагдах дотоодын шаардлагыг биелүүлж дууссан тухай нөгөө Талдаа бичгээр мэдэгдэнэ. Энэхүү Хэлэлцээр нь хоёр мэдэгдлийн хамгийн сүүлийн өдрөөс хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Хэлэлцээрт Талууд харилцан бичгээр тохиролцон нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Уг нэмэлт, өөрчлөлт нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан заалтын дагуу хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү Хэлэлцээр нь түүнийг хүчин төгөлдөр болсны дараа гаргасан аливаа хүсэлтэд хамаарах бөгөөд түүнийг хүчин төгөлдөр болохоос өмнөх үйлдэл, эсхүл эс үйлдэлд хамаарахгүй.

4. Аль нэг Тал нь нөгөө Талдаа энэхүү Хэлэлцээрийг цуцлах мэдэгдлийг хэзээ ч бичгээр хүргүүлж болно. Энэ тохиолдолд Хэлэлцээр нь мэдэгдэл өгсөн өдрөөс хойш 6 сарын дараа хүчингүй болно. Гэхдээ Хэлэлцээрийг цуцлахаас өмнө хүлээн авсан хүсэлтийг Хэлэлцээр хүчин төгөлдөр байгаатай адил Хэлэлцээрт заасан хугацааны дагуу хэрэгжүүлнэ.

Дээр дурдсаныг нотолж, Талуудын Засгийн газраас бүрэн эрх олгосны дагуу энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү Хэлэлцээрийг 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Хонконг хотноо монгол, хятад, англи хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэр тус бүр нь адил хүчинтэй байна. Тайлбарлахад аливаа зөрүү гарвал англи хэл дээрх хувийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ

ЕРӨНХИЙ КОНСУЛ  
САМДАНГИЙН ЭРДЭНЭ

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД  
УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ  
ОНЦГОЙ БҮС ХОНКОНГИЙН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА ЖОН ЛИ

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.25

Индекс: 200003